

“СТРАТЕГИЙН СУДАЛГАА” СЭТГҮҮЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Сэтгүүлд салбар шинжлэх ухааны судалгааны өгүүлэл, нийтлэл, дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг, хурлын мэдээ ирүүлж болно.

1. Нийтлэг шаардлага:

- Бүтээлийн нэр, зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй албан тушаал нь монгол, англи хэл дээр байна.
- Бүтээлээ ирүүлэхдээ зохиогчийн зураг, (800x600 /пиксел/-аас доошгүй нягтаршилтай, GIF, JPEG, PNG өргөтгөлтэй), цахим шуудан, холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байна.
- Бүтээл нь гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өмнө нь хэвлэн нийтлэгдээгүй байх, зохиогчийн эрхийн зөрчилгүй байна.
- Бүтээлийг MS Word программаар, үндсэн бичвэрийг Times New Roman, 11 pt, мөр хоорондын зай 1 (single); эшлэл, зүүлтийг Times New Roman, 9 pt, мөр хоорондын зай 1 (single) хэмжээтэй байхаар бичих бөгөөд .docx өргөтгөлөөр ирүүлнэ.
- Хүснэгт, диаграмм, зургийн эх сурвалж, тайлбарыг шууд доод талд нь налуу үсгээр бичнэ. 2 буюу түүнээс дээш тооны хүснэгт, диаграмм, зургийн өсөх эрэмбээр дугаарлана.
- Эшлэл, зүүлтийн үсгийн хэмжээ 9, мөр хоорондын зай нь 1 /sp/ бөгөөд стандартын дагуу тэмдэглэсэн, гадаад эх сурвалжийг тухайн эх хэлээр нь бичсэн байна.

2. Судалгааны өгүүллийн бүтэц:

- Гарчиг
(монгол, англи хэлээр);
- Түлхүүр үгс
(монгол, англи хэлээр, 5 хүртэлх тооны бүтээлийн гарчигт ороогүй холбоо нэр үгээс бүрдсэн байна.)
- Товчлол
(монгол, англи хэлээр, агуулгыг хураангуйлсан 150-200 үгэнд багтсан бөгөөд өгүүллийн аль нэг хэсгээс шууд хуулбарлаагүй байвал зохино.)
- Үндсэн хэсэг
(Судлаачийн оюуны өмчийг сэтгүүлийн зөвлөл хүндэтгэн үзэх бөгөөд өгүүлэлдээ эш татсан өгүүлбэр, зураг, графикт заавал эшлэл авсан байна.)
- Дүгнэлт, санал
(Үндсэн хэсэгт дурдаагүй санаа оруулахгүй бөгөөд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэх арга зам санал болгосон байвал сайн.)
- Эх сурвалж
(Эшлэлийг хуудас бүрийн дор стандартын дагуу авах бөгөөд ашигласан материалыг өгүүллийн төгсгөлд стандартын дагуу эрэмбээр хавсаргана.)
- Хавсралт.
(Үндсэн агуулгыг тодотгох график, хүснэгт, зураг, холбогдох бусад материал)

Өгүүлэл нь хавсралтын хамт 2500-3800 үгтэй буюу 0.5-1 х.х /A4-ийн 8-16 нүүр/ байна.

3. Эх бичвэрийн стандарт:

№	Стандарт	Стандартын агуулга	
1	Зай хэмжээс	<ul style="list-style-type: none"> • Хэвлэмэл хуудасны талуудын зай болон бичлэгийн мөр хоорондын зайг дараах байдлаар тохируулна. 	
		Хэмжээ	A4
		Үсгийн фонд	Times New Roman
		Үсгийн өндөр /size/	11 pt
		Мөр хоорондын зай /line spacing/	1.15 lines
		Зүүн талаас авах зай /left margin/	3 см
		Баруун талаас авах зай /right margin/	1.5 см
		Дээд талаас авах зай /top margin/	2.0 см
		Доод талаас авах зай /Bottom margin/	2.0 см
		<ul style="list-style-type: none"> • Дээрх хэмжээг баримтлан бичсэн A4 хэмжээтэй нэг талаар 16 хуудсыг тус тус 1 хэвлэлийн хуудас /х.х/ гэж тооцно. • Бичлэгийн догол мөрөөс эхлэх хэсэг /paragraph/ бүрийн өмнө /before spacing/ 6 pt хэмжээтэй зай авна. 	

2	Зураг, хүснэгт, диаграмм	<ul style="list-style-type: none"> • Сэтгүүлд орсон зураг, хүснэгтийг харж унших үед хуудсыг аль болох эргүүлэхгүй байхаар тэдгээрийг байрлуулах ба хэрэв эргүүлэх шаардлагатай бол түүнийг цагийн зүүний дагуу 90°-аар эргүүлэн уншихаар байрлуулна. • Зураг, хүснэгтийг түүний тухай эхлэн дурдсаны дараах тэр хэсэгт оруулна. Зураг, хүснэгт нэг бүр оноосон нэртэй байхын хамт, ойлголтыг тодорхой болгох зорилго бүхий тайлбартай байна. • Хүснэгтийн нэрийг дээд талд нь зургийн нэр, тайлбарыг түүний доод талд бичнэ. Тоон утгаар илэрхийлэгдэх өгөгдөл ихэвчлэн хүснэгтэд бичигдэнэ. • Хүснэгтийг хийхдээ диагональдсан шугам татаж болохгүй бөгөөд толгойн хэсэгт бичигдэж буй тодруулах (багана мөрийн) нэрийг том үсгээр, түүнээс бусдыг жижиг үсгээр эхлэн бичнэ. • Хэрэв хүснэгтийн босоо баганын тоо олон, уг хүснэгт дараагийн хуудсанд шилжих шаардлагатай бол багануудын нэрийг эхнээс нь дугаарлаад дараагийн хуудсанд баганын нэрийг бичилгүйгээр уг дугаараа тавьж болно. • Зураг нь хэвлэлийн шаардлага хангасан, өндөр нягтралтай байх бөгөөд заавал зурган файлаар хавсаргаж өгнө.
3	<p>Эшлэл зүүлт, ашигласан материал</p> <p>Эшлэл, зүүлт авах жишээ</p> <p>Ашигласан материал үйлдэх дараалал</p> <p>Боловсруулалт хийх аргачлал</p>	<p>Хууль, хуульчилсан акт:</p> <ul style="list-style-type: none"> • “Хоршооны тухай” хууль -//Төрийн мэдээлэл. №21/1171. Уб., 2021. т.1534 • “Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай” Ерөнхийлөгчийн зарлиг -//Төрийн мэдээлэл. №23/1173. Уб., 2021. т.1644 • “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт” Монгол Улсын олон улсын гэрээ -//Төрийн мэдээлэл. №23/1173. Уб., 2021. т.1654 • “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай” хуулиас https://legalinfo.mn/mn/detail/14696 (татсан:2022.03.04) <p>Нэг сэдэвт болон хамтын бүтээлээс:</p> <ul style="list-style-type: none"> • Нарангэрэл С. “Эрх зүйн эх толь бичиг”. Уб., 2007. т.45 • Цэрэнбалтав Ц., Минжин Ц. “Тэмүжин-Чингис хааны намтар”. II боть. Уб., 2006. т.607 • Жанцан Н., нар. “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал” (Онол, арга зүйн хэрэгжилт). Уб., 2017. т.139 <p>Сэтгүүлээс:</p> <ul style="list-style-type: none"> • Чимэд Б. “Ард түмний бүрэн эрхт байдал (сувернитет) ба төрийн хэлбэрийн сонголт, цаашдын зорилт” -//Хууль дээдлэх ёс. №3/18. Уб., 2007. т.7 • Энхбаяр Н. “Дэлхийн эдийн засгийн төлөв:Геополитикийн нөхцөл байдал, Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” -//Стратегийн судалгаа. №83/2022. Уб., 2022. т.7 <p>Цахим сайтаас:</p> <ul style="list-style-type: none"> • Kim R.Holmes “What is National Security”. https://www.heritage.org/sites/default/files/2019-10/2015_IndexOfUSMilitaryStrength_What%20Is%20National%20Security.pdf (Retrieved: 2022.03.10) • “Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэв”. http://parliament.mn/n/pw3on (татсан:2022.04.04) <p>Хууль, эрх зүйн актууд</p> <ul style="list-style-type: none"> • Нэг сэдэвт зохиол болон хамтын бүтээл, • Илтгэл, өгүүлүүд • Сонин, сэтгүүлээс авсан материал • Цахим эх сурвалжууд <p>Эшлэлийн заалтыг:</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн хуудасны доод хэсэгт • Эшлэл авсан эх сурвалж дараалан яг давтагдсан тохиолдолд (Мөн тэнд) гэж тэмдэглэнэ. • Эшлэл зүүлт нь тухайн өгүүлэл бүрд шинээр дугаарлагдана. • Эшлэл зүүлтэд тусгагдсан ном бүтээлүүдийг тухайн өгүүллийн эцэст ашигласан материалд бүрэн тусгана. • Ашигласан материалд үгсийн дарааллыг баримтална. • Ном зүйд эхлээд монгол хэл дээрх, дараа нь бусад хэл дээрх бүтээлүүдийг жагсаан бичнэ.